

МОНГОЛ УЛСЫН ГЕОПОЛИТИКИЙН ТӨВИЙГ САХИХ СТАТУС БҮРЭЛДЭН ТӨЛӨВШИХӨД ХӨРШ ГҮРНҮҮДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

П. Цацрал

Докторант, дэд хурандаа, дэд профессор
Хууль сахиулахын их сургууль. Хилийн сургууль

tsatsaa1025@yahoo.com

Abstract: The purpose of this paper is to focus on considering that one of the ways to ensure the current Mongolian external security is the neutrality status, how neutrality status formed as a result of geo politics historical evolution, including comparative study of neighboring countries influence and participation for it.

Key words: Geopolitic, geostrategy, status quo, neighboring countries, Northeast Asian region, interests, zone of influence, neutrality status, peace keeping, peace making

УДИРТГАЛ

XXI зууны эхэнд даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж, олон улсын харилцаа ба бүс нутгийн аюулгүй байдал, олон талт хамтын ажиллагааны цар хүрээ улам бүр өргөжин тэлж, дэлхий нийтийн шинж чанартай болсноор улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг-стратегийн зэрэг бүхий л салбарыг хамарч, улс хоорондын харилцааг өөр хоорондоо нягт уялдаатай, ихээхэн түгээмэл агуулгатай болгосоор байна.

Монголчууд бид болзошгүй аюулаас сэргийлэхийн тулд хоёр хөршийнхөө геополитикийн ашиг сонирхлыг сайтар судалж, Төв Азийн болон Зүүн хойд Азийн бусад орнуудад улс төр, эдийн засгийн бодлогын зохицуулалт хэрхэн явагдаж байгааг ажиглаж, хөгжлийн бодлогодоо оновчтойгоор тусгаж байх нь улс орны аюулгүй байдал, хөгжил дэвшилд эерэгээр нөлөөлөх болно.

Монгол Улсыг хүрээлсэн орон зайд “Хүйтэн дайн”-аас хойш гарсан эрс өөрчлөлт, түүний цаашдын хандлага нь биднийг ирээдүйн хөгжил, аюулгүй байдлын асуудлаа Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн Хойд Азийн хүрээнд авч үзэхэд хүргэсэн билээ.

ОХУ-ын хувьд Төв Азид хамгийн хүчтэй нөлөөлж чадах улс. Өөрөөр хэлбэл, цэрэг улс төр, эдийн засгийн хувьд Төв Азид шахалт үзүүлэх бүхий л арга хэрэгсэл бий. Төв Азийн орнуудын эдийн засгийн гол хөдөлгүүр болох аж үйлдвэрүүдийн ихэнх нь ОХУ-ынх байдаг учраас Оросгүйгээр

тэд хөдлөх боломжгүй.²² Төв Азийн улс орны газрын тос, байгалийн хийн хоолой, автозам, төмөр зам гээд бүхий л холбоо, дэд бүтэц Оросын нутгаар дайрдаг. Энэ нь ОХУ-д Төв Азийг хянах боломж, давуу талыг олгодог юм. Гэвч сүүлийн жилүүдэд Оросын эдийн засаг тогтворгүй байгаа явдал Хятадад Төв Азид эдийн засгийн бодлогоо тайван хэрэгжүүлэх шинэ боломжийг өгч, Бээжин тус бүс нутагт эдийн засгаар халхавчилсан улс төрийн бодлогоо явуулж байна. Зүүн Хойд Азид хамгийн хүчтэй нөлөөллийн нэг голомт нь Хятад улс байгаа юм. Геостратегийн хувьд Монголын улсын хамаарч буй Төв болон Зүүн Хойд Азийн бүс нутагт гол нөлөөлөгч, хүчний тэнцвэрийг хадгалагч төвүүд нь яалт ч үгүй манай урд болон хойд хоёр хөрш улсууд байгааг бид бэлхнээ харж буй юм.

Геополитикийн амьдралыг шинжлэх ухааны үүднээс танин мэдэхэд шаардагддаг харьцуулалт, адилтгах, экстраполяц (үзэгдлийн нэг хэсэг дээрх ажиглалтаас гаргасан дүгнэлтийг түүний нөгөө хэсэгт хэрэглэх судалгааны арга)-ийн аргууд болон ард түмэн, улс орны амьдралаас гарсан онолын мэдлэгийг ямагт ашигладаг боловч туршилт судалгааг өргөн хэрэглэдэг²³. Энэ нь геополитикийн амьдралын бүх хүчин зүйлсийн анализыг эзэмших замаар хийгддэг бөгөөд дэлхийн геополитикийн зураглал дээрх бүс нутгийн ба глобаль өөрчлөлтүүдийг тайлбарлах, ойлгоход чухал урьдчилсан нөхцөл болдог. Уг өгүүллийг боловсруулахдаа геополитикийн дээрх судалгааны аргуудыг ашиглахын зэрэгцээ түүхчлэн харьцуулах, анализ, синтез, индукци, дедукци гэх мэт ерөнхий логик аргуудыг хэрэглэж, хөрш улсуудын геополитикийн нөлөөллийн цаашдын объектив хандлагын төсөөллийг дэвшүүлэн тавьж, суралцагсад олон улсын харилцаа, геополитикийн хичээлийн хүрээнд ашиглах боломжтой мэтгэлцээний суурь хэрэглэгдэхүүн болгохыг зорьсон.

Энэхүү өгүүлэлд Евразийн орон зайд нөлөөгөө хадгалах ОХУ болон БНХАУ-ын бодлого, чиг хандлага, түүхэн улбаа, Монгол Улсын геополитикийн орон зайд хэрхэн нөлөөлж ирсэн түүх, цаашид анхаарах асуудлын талаар санал дэвшүүлэхийг оролдоно.

Нэг. Монгол Улсын геополитикийн онцлог нөхцөл. Түүхэн хувьслын үрээр улс гүрнүүд нэг нэгнээ ноёлохын төлөө байлдаж, улс гүрэн үүсч, зарим нь мөхөж, хүчтэй нь хүчгүйгээ агуулсаар өнөөгийн олон улсын эрх зүйн хүрээнд бие даасан тусгаар улсууд бүрэлдэн буй болсон.

Өнөөдөр монголыг дэлхийн хоёр том гүрний дундах түгжигдмэл жижиг орон гэж зарим улсууд үзэж байхад түүхийг сөхөн харвал Германы

²² *How The Russia-China Strategic Partnership Marks A New Global Power Shift, By Pepe Escobar*
<http://www.alternet.org/world/how-russia-china-strategic-partnership-marks-new-global-power-shift>

²³ Нартов Н.А. Геополитик. УБ.,2003, 30-р тал.

философич Гегель “Хүн төрөлхтний түүх монголчуудаас эхэлнэ. Монголчууд хүн төрөлхтний түүхийг оюун сүнстэй болгосон” гэсэн байдаг. “Монголын гүрэнт улс байгуулагдахаас өмнө Хятад 12 тусдаа улс байсныг нэгтгэж одоогийн Хятадыг бүрэлдүүлсэн байхад, мөн ОХУ Уралаас баруун тийш 62 вант улс байхад монголчууд Москвагийн вант улсыг дэмжиж, Орос гүрний суурийг тавьж өгсөн. Тэгэхээр монголчууд өөрсдийнхөө хоёр бүтээлээр битүү хүрээлүүлчихсэн байгаа юм. Улсынхаа хязгаарыг урд талдаа Өмнөд Монгол, Ганшу, Шиньжан гэх монгол угсаатны эртний овог аймгуудаар, хойд талдаа Тува, Буриад, Ойрадуудаар хүрээлүүлж байгаа хэрэг”²⁴ хэмээн манай нэрт геополитикч, Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн лекцэндээ дурдсан байх юм.

Дэлхий нийтийг хамарсан ямар ч донсолгооноос аливаа улс ангид байж чадахгүй агаад газар зүйн хүчин зүйл бүр мөсөн үгүйсгэгдэхгүй нь үнэн. Тиймээс аливаа улсын үндэсний аюулгүй байдлын орчин шууд хаяа нийлэн орших бүс нутаг, хөрш орнууд дахь өрнөлтөөс шууд хамааралтай. Тэгвэл Монгол Улсын эргэн тойрон дахь аюулгүй байдлын орчинд ямар өөрчлөлт гарч байна вэ? гэдгийг судлахын тулд гадаад, дотоод цагийн байдлыг түүхэн улбаан дээр тулгуурлан судлах шаардлага гарч байгаа юм.

Монгол Улс нэг талаасаа геополитикийн таатай нөхцөлд оршин тогтнож буй. Стратегийн түншлэлийн харилцаатай найрамдалт хоёр хөршөөр хүрээлэгдсэн энэхүү байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд шууд заналхийлэх аливаа аюулыг магадлалын түвшинд бүрэн үгүйсгэж болохуйц нөхцөл мөн. Үүн дээр хоёр хөршийн тогтвортой, хүчтэй төр засагтай тогтолцоо нь дэлхий дахиныг хамарсан уламжлалт бус зарим аюул занал, тухайлбал, олон улсын терроризм, мөн бусад бүс нутагт гарсаар буй иргэний дайн самуун, зэвсэгт бүлэглэлүүдийн үйл ажиллагаа манай хил хязгаарыг даван нэвтрэх бололцоог тодорхой хэмжээнд хааж байна. Гадаад аюулгүй байдлын харьцангуй таатай ийм орчинд оршин тогтнож байгаа улс тийм ч олон бус. Гэвч энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад орчин аливаа эрсдлээс бүрэн хамгаалагдсан байна гэж тайвшрах үндэс болох учиргүй.

Их гүрнүүдийн нөлөөллийн орон зайд орших, тэдний геополитикийн сөрөг нөлөөнд ихээхэн эмзэг өртөмтгий буюу тийнхүү өртөх аюул занал, эрсдэл дор оршдог, өөрийгөө өөрийнхөө хүчээр хамгаалах чадал буурай, товчоор олон улсын тавцанд өөрийгөө хадгалан үлдэх буюу тэсч үлдэх бодлого баримталдаг улсыг жижиг улс гэж хэлж болно.²⁵ Жижиг

²⁴ Бямбасүрэн Д. Монголчуудад мэдлэгээ баялаг болгохуйн ухаан хэрэгтэй байна. *Өдрийн сонин*. УБ., 2016, 12, 5, №279, 12-р нүүр.

²⁵ Аюулгүйн манаанд 90 жил. *Эрдэм шинжилгээний хурал*. УБ., 2012, 150-р тал.

улсуудын²⁶ хувь заяа их төлөв тэдгээрийн хилийн гаднах үйл явцаас ихээхэн шалтгаалах ба олонх жижиг улс бүс нутаг, дэлхий дахины шинжтэй хямрал, мөргөлдөөнд илүү өртөмтгий байдаг. Жижиг улс өөрөөс хүч чадлаар илүү улсуудтай хөрш зэргэлдээ оршдог бол түүний гадаад бодлогод болгоомжлолын хүчин зүйл заавал үйлчилж, хөрш том орнуудын хүч чадал нэмэгдэх тусам хөрш зэргэлдээ жижиг улсуудын аюулгүй байдал эмзэг болдог байна. Энэ нь Монголын өнөөгийн статуст илүү ойр тодорхойлолт мэт санагдана.

Хоёр. Хөрш гүрнүүдийн нөлөөллийн бүс болох нь. Монгол Улсын сүүлийн 200-300 жилийн түүх энэ хоёр улсын бодлогоос хамаарсаар ирсэн. ХХ зууны 50-аад он хүртэл хоёр хөршийн нууц гэрээ хэлэлцээр, хуйвалдааны үр дүнд урд хөршид хамааралтай байгаад хойд хөршийн нөлөөллөөр тусгаар тогтнолоо зарлаж, дэлхийн II дайны дараа БНХАУ бий болоход Орос, Хятадтай тэнцвэртэй харилцаатай байсан. Гэтэл 1960-аад оны эхээр хоёр хөршийн харилцаа муудсанаас бид аль нэг талд нь сонголт хийх болоход ЗХУ-ыг дагасан. Үр дүнд нь оросын цэрэг манайд байрлав. Өмнөд хөрштэй 1960-аад оны дунд үеэс 1980-аад он хүртэл дайсагнасан харилцаатай байж ирсэн. Бид түүхэндээ хөршүүдийнхээ аль нэгний хамааралтай байж ирсэн явдал нь бие даасан гадаад бодлогыг бүрэн үгүйсгэж байсан юм. 1990 оны Ардчилсан хувьсгалын үр дүнд бие даан гадаад бодлого явуулах, үндэсний гадаад аюулгүй байдлаа сахин хамгаалах их үйл хэргийг хууль эрх зүйн хүрээнд батламжилсан юм. Өнөөдөр Монгол Улс хоёр хөрштэйгээ стратегийн өндөр түвшний харилцаатай болсон.

Их гүрэн хүссэн хүсээгүй түүний бодлого жижиг улсуудад аяндаа нөлөөлдгийг XIX-XX зууны эхэн үеийн Монголын гадаад улс төрийн түүхээс харж болохоор байна.

Манж Чин гүрэн Монголыг эрхшээлдээ оруулж, 200 гаруй жил эзэрхийлж байсан түүх, тусгаар тогтнолын асуудлыг эерэг, таатай байр суурин дээр байсан тухай гадаадын монгол судлаачид ойролцоо санал дүгнэлтүүд гаргасан байх юм. Тухайлбал: 1910-аад оны үед Монгол нутгаар аялж байсан Оросын судлаач В.Котвичийн тэмдэглэлдээ “Манж Халхыг Ойрадоос хамгаалж, урьдын бэлчээрийг эргүүлэн өгч, засаг захиргааг шинээр эмхлэх санаа гаргаж, Халхыг номхотгоход тал засан” өөртөө татах зорилт дэвшүүлжээ, Тэд нэг талаас хошуудын засаг ноёдын тоог олшруулж, нөгөө талаар шарын шашныг дэлгэрүүлэн, монголчуудын

²⁶ Дэвид Вайтал “их гүрнүүдийн хүч нөлөөнд хавсрага болж, олон улсын улс төрд бие даан оролцож чаддаггүй, нэгдүгээр зэрэглэлийн улсын улс төр, цэргийн хүчний дайвар болдог улс”, судлаач, доктор Ё.Отгонбаяр “өөрийн статус-кво өөрчлөлт гарахаас сэргийлэх чадваргүй буюу сөрөг нөлөөллөөс өөрийг хамгаалах чадваргүй улс” гэх мэтээр тодорхойлсон байдаг.

догшин занг номхруулан, дайчин үйл хэрэг гэхээс илүү сэтгэлийн авралыг олох эрмэлзэлийг төрүүлэхийг чухалчилжээ. Дайчин нүүдэлчид удалгүй энхийг эрхэмлэн номхорч, эрчүүдийн ихээхэн хэсэг нь лам хуврага болжээ”²⁷.

Японы монголч эрдэмтэн Наками Тацүо өөрийн судалгаандаа “Чин гүрэн Монголд ноёрхож байсан үед Манжийн эзэн хаан болон түүний Монгол сурвалжит албатуудын харилцаа үндсэндээ туйлын зохистой (идеальны) гэмээр байв. Монгол ноёдын хууль ёсны байдал, статусыг Манж-Чингийн эзэн хаан баталгаажуулж, энэхүү харилцаа улс төр, шашин, эдийн засаг, соёл зэрэг бусад чухал харилцаа явагдах хүрээг бүрдүүлж байв. Манжийн хаад Монголын лам хуврагуудын хамгийн чухал бөгөөд гол дэмжигчид байв. Чингийн эзэнт гүрний хүрээнд Монгол нь “бүдүүн баараг, дуулгавартай холбоотон” байв. Монголчууд дахин нэгдэж цэргийн аюул занал учруулахаас сэргийлэх үүднээс Чингийн дэглэм Монголын ноёдыг хяналтандаа байлгаж байв. Түүнээс гадна хятадуудыг Монголын нийгэмд хэт ойртуулахгүй байх бодлого баримталж байв. Энэ нийгмийн бие даасан бүтцээ хэвээр хадгалан авч үлдэх боломжийг монголчуудад олгосон нэг хүчин зүйл байв.”²⁸ гэж дүгнэжээ.

Гэвч 19-р зууны дунд үед Чингийн дэглэм хоёр талаасаа, тухайлбал гадна талаасаа Империалист гүрнүүдийн зүгээс бүрэн эрхт байдалд халдах өнгөлзлөгөд, дотор талаасаа хүч, нөлөө нь нэмэгдсэн хятадуудын аюул заналд тус тус дайрагдан өөрчлөгдөж байв. Чингийн захиргаан дахь Монголын нийгэм ч гэсэн хямралд автан алгуур боловч тууштай өөрчлөгдөж, Хятад худалдаачид Халх Монголыг Говь цөлөөс цааш түрэн, худалдааны сүлжээ бий болгосон.

Манж Чин гүрэн бууран доройтож, Монгол, Хятадын ард түмэн үндэсний эрх чөлөөгөө тунхаглах тэрхүү түүхэн цаг үед гуравдагч улс орнууд болох АНУ, Японы ашиг сонирхол илэрхий хүч түрэн орж ирснийг дараах баримтуудад тусгагджээ.

АНУ нь XIX зууны эхээр бусад империалист гүрнүүдийн дэргэд улс төр, худалдааны нөлөө нь сулхан, Европоос тусгаарлагдмал, алс Дорнодод цэргийн бараг оролцоогүй байжээ. Иймд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон Т.Рузвельт Азид идэвхтэй бодлого баримтлахаа мэдэгдэж, улмаар алс дорнодод бусдаас хоцорсон өөрийн нөлөөг нөхөн тогтоох бодлогыг XX зууны эхээр идэвхтэй явуулжээ. 1900 онд АНУ Азийн түүхэнд “Нээлттэй хаалганы бодлого” гэж нэрлэгдсэн мөн чанар нь Чин

²⁷ Котвич.Вл. Монголын түүхийн хураангуй тэмдэглэл ба түүний эдүүгээгийн улс төрийн байдал. СП.,1914. УБ.,2011, 15-р тал.

²⁸ Наками Тацүо “Үндэстэн улсаа байгуулахыг зорьсон нь: Монголын тусгаар тогтнолын 1911 оны тунхаглал” Монголын тусгаар тогтнол ба монголчууд. ЭШБХ. Ред С.Чулуун УБ.,2012, 12-р тал.

Улсын бүхий л газар нутагт америкийн худалдаачдыг нэвтрүүлэхэд чиглэсэн “...Хятадын газар нутаг, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хадгалан ... Хятадын эзэнт гүрний бүх хэсэгтэй тэгш, үл ялгаварлах худалдаа хийх зарчмыг бататгах” саналыг бусад гүрнүүдэд хандан дэвшүүлжээ.

Орос, Японыг 1905 онд зуучлан найрамдуулсан нь АНУ-аас Азид хийсэн дипломат хоёр дахь томоохон алхам байв. Портсмутын гэрээгээр Хаант Орос, Япон хоёр нээлттэй хаалганы зарчмыг Манжуурт хүлээн зөвшөөрсөн нь АНУ-ын оролцоог хүлээн зөвшөөрсөн хэрэг байв.²⁹

Америкийн түүхч Берд...нар бичихдээ “нээлттэй хаалганы бодлогыг хэрэгжүүлэхээр Рузвельт, Тафт нарын дорх Төрийн нарийн бичгийн дарга Хей болон түүний удаах хүмүүс ... Солонгос, Манжуур, Монголд эдийн засгийн талаар нэвтрэхэд үргэлжлэн анхаарснаар Оросын ашиг сонирхолтой мөргөлдөхөд хүргэжээ”³⁰ гэсэн байна.

Ар Монгол АНУ-ын анхааралд өртөж эхэлсэн бөгөөд АНУ-ын анхаарлыг Манжуураас холдуулахын тулд хаант Орос Хүрээ-Хиагтийн хэсгийг Оросын тал барих нөхцөлтэйгээр Хаалган-Хүрээ-Хиагтын төмөр зам барихыг 1910 оны эхээр АНУ-д санал болгожээ. Оросын сангийн сайд Коковцев Элчин сайд Рокхилльд “Хиагт-Хаалганы шугам хэдийгээр Оросын эдийн засгийн ашиг сонирхолд дутахгүй хохиролтой боловч стратегийн хувьд байж болох шугам” гэж 1910 оны 3 сард уулзахдаа тэмдэглэж байжээ.³¹

Ар Монгол тусгаар тогтнолоо зарласныг Бээжинд суугаа Америкийн Элчин сайд Кэлхаун Вашингтонд цахилгаанаар яаралтай 1912 оны 1 дүгээр сарын 8-ны орой /Оросын тооллоор бол 1911 оны 12 дугаар сарын 29-нд/ мэдэгдсэн байна. Цахилгаанд Оросын хяналт дор дотоод хэргээ мэдэх Ар Монголын тусгаар тогтнолыг Хятад хүлээн зөвшөөрч, харин гадаад харилцааг нь хянах, Хятадын талаас Хиагт-Хүрээний хооронд төмөр зам барихыг Орост зөвшөөрөх, Ар Монголыг колоничлохгүй цэргээ байрлуулахгүй байхыг Оросын тал шаардсан байна гэжээ. Т.Нокс мөн өдөр нь “бусад элчин сайд нар засгийн газрууддаа энэхүү асуудлаар ямар зөвлөмж өгч байгааг мэдэх, нөхцөл байдал болон цаашид авах арга хэмжээний талаар саналаа ирүүлэх”-ийг зааварлажээ.

Бээжин, Санкт Петербургт суугаа АНУ-ын ЭСЯ-даас Ар Монголын талаар судалгаа, мэдээллийг Төрийн департаментэд 1910 оноос эхлэн

²⁹ Болд Р. Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын эхний хандлагын тухайд. Мөн тэнд, 70-р тал.

³⁰ *The Rise of American Civilization. By Charles A. Beard And Mary R. Beard. Two Volumes, 1937 The Macmillan Company, New York. p.1495.*

³¹ *U.S Department of State. Records relating to the Internal Affairs of China 1910-1929. 893. 77/869*

тогмол илгээж байжээ. Иймд Монголд болж байсан үйл явдлын талаар Вашингтон мэдээлэлтэй байв. Гэвч АНУ Ар Монголыг Хятадын бүрэлдэхүүн гэж үзэж байв. АНУ-ын Ерөнхийлөгч Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн мэдэгдэл хүртэл хийж байсан нь Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээсэн нь Алс дорнодод нөлөөлсөн чухал үйл явдал байсныг харуулна.

Богд хаант Монгол улсын засгийн газар тусгаар тогтносон тухайгаа АНУ-д мэдэгдсэн, худалдааны харилцаа тогтоохыг санал болгосон, Орос Хятадын тунхаглалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа тайлбарласан зэрэг гурван захидлыг АНУ-ын засгийн газарт хүргүүлж чадсан байна. Америкийн тал ч эдгээр ноот захидлуудыг хүлээн авчээ. Ингэснээр тухайн төвөгтэй нөхцөлд Монголын талын оролдлого дипломат зорилтоо хангасан гэж үзэхээр байна.

XX зууны эхэн үеийн энэхүү түүхэн мөчлөгийн онцлог нь геополитикийн хувьд их гүрнүүд дэлхийг дахин хуваах бодлого эрчимтэй эхэлсэн үе байсан юм.

Монгол Улсын олон улсын статусын асуудал 1911-1924 онуудад хэд хэдэн олон улсын гэрээнд өөр өөр байдалтай тусгагдсан байдаг. Тухайлбал,

Нэгд, Орос-Монголын 1912 оны гэрээ, Орос-Хятадын 1913 оны тунхаг, Орос-Монгол-Хятад гурван этгээдийн 1915 оны Хиагтын гэрээг, 1924 оны Зөвлөлт Хятадын хоорондох асуудлуудыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай гэрээ зэрэгт Хятадын эзэн эрхийн дор орших болон түүний бүрэлдэхүүн дэх Гадаад Монголын автономит эрхтэй улс хэмээн заасан.

Хоёрт, 1913 оны Монгол-Төвдийн гэрээ, мөн түүнчлэн ЗСБНХОУ ба Монголын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай 1921 оны гэрээ зэрэг Монгол улсын бие даасан байдал, тусгаар тогтнолыг тус тус хүлээн зөвшөөрсөн байдаг³² аж.

Монгол нь 1911-1945 онд де-факто буюу бүрэн бус шинжийг агуулсан байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн байсан. Үндэстний төрт-улсын хэлбэрээр Монгол нь оршин буй тэр бодит баримтыг холбоотон их гүрнүүд хүлээн зөвшөөрснийг Ялтад байгуулсан хэлэлцээрт “Гадаад Монголын статус-квог хадгална” гэдгээр нэгдүгээр заалт болж орсон.

Де-юре буюу дипломатын талаас бүрэн хүлээн зөвшөөрөх хэлбэрийг 1945 онд их гүрнүүдээс хэн нь ч сонгоогүй. 1921 онд Зөвлөлт Орос ба Монголын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосон байдаг боловч хожим нь СССР нь энэ тохиролцооноосоо ухарсан мэт 1924 онд

³² Урангуа Ж. Монголын тусгаар тогтнол: Орос-Хятадын 1913 оны Бээжингийн тунхаг. 113-р тал.

Бээжинд байгуулсан СССР ба ДИУ-ын хоорондын асуудлуудыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай Хэлэлцээртээ Гадаад Монгол нь Дундад Иргэн Улсын (ДИУ) салшгүй нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрснөөрөө де-юре хүлээн зөвшөөрснөө де-факто болгож хувиргасан, тэр чигээрээ 1945 он хүрсэн байв³³.

Харин Ялтад томъёолсон “Гадаад Монголын статус-кво” гэдгээ СССР нь “БНМАУ-ын тусгаар тогтнол” гэж томъёолон 1945 оны зун Гоминданы Хятадад тулгаж зөвшөөрүүлжээ. 1945.08.14-нд Зөвлөлт Холбоот Улс, ДИУ-ын хооронд Найрамдал, холбооны тухай гэрээнд гарын үсэг зурсан ба гэрээг ноот дагалдсан, түүнд “БНМАУ-ын тусгаар тогтнолыг ДИУ хүлээн зөвшөөрнө” хэмээн заажээ. Ноот дээрхи заалтын дагуу Хятадын тал Гадаад Монголын хүн амаас санал асуулгах болж, тэр оны намраа тусгаар тогтнолоо баталсан санал хураалтыг монголчууд зохион байгуулж, Хятадаас эгнэгт саллаа гэдгээ нотолжээ.

Ийм үед ДИУ де-факто Монголыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болж 1946.01.05-нд Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, 1946.01.13-нд дипломат харилцаа тогтоожээ. СССР-ийн хувьд де-факто болгож хувиргасан харилцаагаа 1945 онд де-юре болгоод харин хоёр талын ямар бичиг баримтаар баталгаажуулав гэхлээр 1946.02.27-нд Москвад гарын үсэг зурсан “Нөхөрлөл ба харилцан туслалцах тухай гэрээ”-г үндэс болгов.

XX зууны Монголын тусгаар тогтнолын баталгаажилт, уналт, бууралтын түүхийг дээрх хэдэн баримтууд дээр тулгуурлан дүгнэхэд геополитикийн хувьд дэлхийд шинэ тоглогч болон гарч ирж байсан Дундад Иргэн Улс, Зөвлөлт Холбоот Улс, АНУ, Япон зэрэг улсуудын геополитикийн ашиг сонирхлын давхцал, зөрчил, тэдгээрийн хоорондын ил, далд нууц хийсэн гэрээ хэлцлүүд, улс төрийн үйл явцууд нь түүхэн тодорхой хугацааны дараа төвийг сахих статус руу аажмаар хөтлөн оруулсныг харж болохоор байгаа юм.

1980-аад оны сүүлчээр социалист хамтын нөхөрлөлийн орнуудын нэгдсэн тогтолцоо задран тарсны дараагаар Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны тухай ойлголтыг шинэчлэх, юуны өмнө, хоёр их хөрш мөн бусад улс оронтой яаж харилцах, энэ хүрээнд аюулгүй байдлаа хэрхэн бие дааж хангах вэ? гэдэг асуудлыг шийдвэрлэхийн тулд гадаад бодлогодоо зарчмын өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага манай улсын өмнө тулгарсан билээ.

Энэ асуудлыг зөвөөр шийдвэрлэхийн тулд юуны өмнө хөрш хоёр их

³³ Цацрал П. Олон улсын харилцааны онолын үндэс, Геополитик судлал. УБ.,2016, 135-р тал.

гүрэнгэйгээ адил тэнцвэртэй, бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал гэдгийг Монгол Улс өөрийнхөө гадаад бодлогын үндсэн чиг баримжаа болгосон юм. Ингээд эдгээр улстай харилцах зарчмын цоо шинэ хандлагад тулгуурлан 1993 онд ОХУ-тай, 1994 онд БНХАУ-тай “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-г байгуулсан болно³⁴. Үүний зэрэгцээ манай улс АНУ болон Зүүн Хойд Азийн бүс нутгийн нөлөө бүхий бусад оронтой идэвхтэй хамтран ажиллах чиг шугам буюу “Гуравдагч хөрш”-ийн хэмээн нэрлэдэг бодлогыг баримталж эхэлсэн бөгөөд үүнийгээ аль хэр ухаалаг, оновчтой, алсын хараатай хэрэгжүүлж чадахаас манай орны аюул гүн байдлын ирээдүй хамаарна гэж судлаачид үзсэн байна.

Өнгөрсөн 25 орчим жилд Монгол Улсаас БНХАУ болон ОХУ-тай тогтоосон найрамдалт харилцаа ихээхэн үр дүнтэй хөгжиж, улам бүр гүнзгийрсээр байгаа бөгөөд энэ нь манай орны хөгжил, аюулгүй байдлын гол баталгаа болж буй юм.

Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улс хөрш хоёр оронтойгоо тогтоосон энэ найрамдалт харилцаагаа шинэ шатанд гарган гурван талт буюу гурвалсан хамтын ажиллагаа болгох, ингэхдээ хоёр их хөршийнхөө хамтын ажиллагааны найдвартай холбоос гүүр болох сонирхолтой байгаагаа илэрхийлэх болсон билээ.

2014 оны 9 дүгээр сарын 11-нд Тажикстаны нийслэл Душанбе хотноо БНХАУ, ОХУ, Монгол Улсын төрийн тэргүүн нарын нүүр тулсан анхны уулзалт болсон нь манай гурван орны найрамдал, хамтын ажиллагаанд шинэ буюу тэр үед хэвлэл, мэдээллийн зарим хэрэгслээр тэмдэглэж байснаар олон улсын харилцаанд “стандарт бус” үзэгдэл болсон юм. Дэлхийн улс орнуудын гадаад харилцаанд төрийн тэргүүн нарын нүүр тулсан хоёр талын уулзалт болдог нь байдаг уламжлал. Харин энэ уулзалт шиг гурван талын уулзалт тэр болгон болоод байдаггүй бөгөөд олон судлаачид түүхэн хэмээн нэрлэсэн байна.

Монголын хөрш орнуудын гурвалсан хамтын ажиллагаа дөнгөж эхэлж байсан тэр үед БНХАУ-ын дарга Си Жинпин “Сайн эхлэл бол хагас амжилт”; хэмээн онцолсон бол ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин Монгол Улсын саналыг “зөв зүйтэй санаачилга” гэсэн байна. Гэхдээ дараагийн уулзалтуудыг аль нэг улсдаа ээлжлэн хийж байх, тэгэхдээ одоо байгаа яриа хэлэлцээрийн түвшнийг ахиулсан хэлбэр учраас ШХАБ-ын хүрээнд ч ийм гурвалсан уулзалтуудыг хийж болох юм гэсэн саналыг хэлсэн байдаг.

³⁴ Галсанжамц С. Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын хамтын ажиллагаа ба Монгол Улсын оролцоо. 2018 оны 7 дугаар сард Бээжин хотноо болсон олон улсын хуралд тавьсан илтгэлийн товчлолоос.

Түүнчлэн сүүлийн 14 жилийн хугацаанд ШХАБ-д ажиглагчаар байсан Монгол Улс ойрын үед энэ байгууллагын жинхэнэ гишүүн болж магадгүй хэмээн яригдаж байна. Ер нь энэ байгууллагад жинхэнэ гишүүнээр элсэх эсэх нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, геополитикийн тэнцвэрт байдлыг хангахад шийдвэрлэх үүрэг бүхий асуудал болон тавигдаж магадгүй гэж зарим хүмүүс үзэж байхад, зарим судлаач Монгол Улс ШХАБ-д эслэхийн буруушааж, харзнах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Тухайлбал, *МУИС-ийн Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургуулийн багш, доктор С.Баясгалан*: “ШХАБ-д элслээ гэхэд хоёр хөршөөс бодлогын шахалт ирэхийг үгүйсгэхгүй” гэж үзэл бодлоо илэрхийлсэн байна. Тэрээр үзэхдээ: “Манай улсын нэн тэргүүний бодлого бол худалдаа эдийн засгийн интеграцид орох. Гэтэл бидний ойр тойронд ямар ч интеграци алга. Хамгийн ойр нь АПЕК. Харамсалтай нь шинээр гишүүн элсүүлэхгүй гэж байгаа. Монголын хувьд ч Номхон далайн орон гэхээс илүү Төв Азийн орон учраас боломжгүй. Мөн ШХАБ худалдаа эдийн засгийн бүрэн хэмжээний интеграци болоогүй байгаа учраас Монголын эдийн засагт хувь нэмэр оруулахуйц нөлөө бүхий улс орон хоёр хөршөөс өөр алга. Тиймээс элсэж орно гэж яарах хэрэггүй гэж харж байна” гэж үзжээ. Энэ ч өнөөгийн хөрш улсуудын ШХАБ дахь бодит нөхцөл байдалтай нийцэж буй юм.

Тус бүс нутаг дахь эдийн засгийн хамтын ажиллагаа гэдэг бол зөвхөн хоёр талын харилцаа голлосон, гурван орны хооронд явцуу ямар нэгэн асуудлыг хамарсан хөтөлбөр хэлбэртэй явагдахаас өөр гарцгүй, тодорхой механизм бий болохгүй явсаар XXI зууны 20-н жилийг туулах магадлалтай боллоо.³⁵ Ийнхүү бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд БНАСАУ-д буй болсон дэглэм ойлгомжгүй, барьцгүй байр суурь баримталсаар байгаа боловч сүүлийн 1 жилийн хугацаанд их гүрнүүдтэй харилцах харилцаанд харьцангуй нааштай алхамууд хийгдэж, БНСУ, АНУ, ОХУ, БНХАУ зэрэг улсуудын төрийн тэргүүнтэй тус улсын удирдагч Ким Жон Ун төрийн дээд хэмжээний уулзалт зохион байгуулж, зарим нэг зөвшилцөлд хүрч буй явдал нь Солонгосын хойгийн цэргийн аюул заналын тодорхойгүй нөхцөлийг зөөллөх нааштай үзэгдэл болж байгааг шинжээчид тэмдэглэж байгаа юм. НҮБ-ын мандатын доор явагдаж буй энхийг сахиулах ажиллагаануудад Монголын цэргийн албан хаагчид амжилттай оролцож, үүргээ нэр төртэй биелүүлж нь манай орны нэр хүндийг олон улсын тавцанд өргөхийн зэрэгцээ үндэсний Зэвсэгт хүчний чадавхыг олон улсын стандартад ойртуулах бололцоог бас олгож байгаа юм. Монголын Зэвсэгт хүчний энэ

³⁵ Дагважамц Г. *XXI зууны эхэн үеийн Монгол Улсын геополитикийн орчин. УБ., 2014, 145-р тал.*

оролцоо нь өнөөдөр Зүүн Хойд Азийн улс орнуудын энхийн төлөө хамтын ажиллагааны салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болоод байна.

Гурав. Геополитикийн төвийг сахих статусын төлөвшил. Сүүлийн жилүүдэд аюулгүй байдлын орчны өөрчлөлт асар хурдацтай өрнөж, хэдэн арванаар тоологдох хугацаанд бус, жил, сар, өдрөөр хэмжигдэн тасралтгүй хувирч, тэр хэмжээгээр аюулгүй байдлаа хамгаалах хамтын болон шинэ арга хэрэгслүүдийг улс орнуудаас шаардах болов.

Манай гадаад бодлогын үзэл баримтлал дахь хөршүүдтэйгээ найрсаг, тэнцүү харилцана гэдгийн цаана төвийг сахих санаа агуулагдана. Монгол Улсын өнөөдрийн энэ тусгаар тогтнол нь эргээд л бидний өөрсдийн боловсруулсан гадаад бодлого, түүний дотор нэрлэж хэрэглэж байгаагүй ч хэн нэгний талд орохгүй гэсэн тэр төвийг сахих бодлогын ач гавьяа юм.

Түүхчдийн тэмдэглэсэнээр монголын өмнөх төр улсын үед ийм тодорхой бодлоготой байсан байдаг. Жишээлбэл, “Төвийг сахисан улсыг найртайгаар үзэх зарчим” нь Монголын Хөх төрийн эздээс боловсруулсан гадаад харилцааны 12 зарчмын нэг нь байжээ. Тэрнээс хойшхи түүхэнд бусдын эрхшээлд байж, үүнээс хэрхэн гарах нь эх орончдын зүрх сэтгэлийг эзэмдсэн гол хүсэл зориг болж ирсэн. XX зууны эхэн үед “Швейцар лугаа” гэсэн санаа дэвшүүлжээ. Монголын эх орончид ингэж ярих болсон шалтгаан нь эргээд улсаа аварч үлдэх асуудалтай холбоотой байж. Тун удалгүй социализмын хязгаарлагдмал үед Монгол нь харин ч “Төвийг сахихгүй” улс болсоноо тунхагласан. Тэр үед бид “Коммунист блокийн гишүүн байна. Эдийн засгийн харилцан туслах нийгэмлэгийн гишүүн байна” гэж социалист лагерьт өөрсдийгөө хамааруулсан. Үүний үр дүнд улс төрийн тусгаар тогтнолоо алдах дөхсөн.

Төвийг сахих гэдэг нь “neuter” (дундаж) гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд дайн байлдаанд оролцохгүй, энхийн цагт цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй байхад чиглэсэн гадаад бодлогын статус юм. Төвийг сахих статусыг олон улсын эрх зүйгээр дайны үед төвийг сахих, байнга төвийг сахих гэсэн хоёр төрөлд хувааж үзэх хандлага тогтжээ. Дайны үед төвийг сахисан улс нь дайн байлдаанд оролцохгүй, дайтагч талуудад туслахгүй, нутаг дэвсгэрээ ашиглуулахгүй, тэдгээртэй адил тэнцүү харилцах үүрэгтэй. Мөн идэвхтэй, идэвхгүй гэж нэрлэх нь ч бий.

Байнга төвийг сахисан улс нь дайн байлдаанд оролцохгүй байхаас гадна энхийн цагт бусад улсын эсрэг хүч хэрэглэхгүй, дайн эхлүүлэхгүй, цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй, гадаадын цэргийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх зэрэг үүрэг хүлээдэг. Төвийг сахисан улс гадны халдлагад өртвөл өөрийгөө хамгаалах болон бусад улс, НҮБ-аас тусламж хүсэх эрхтэй байдаг байна.

Олон улсын эрх зүй нь төвийг сахих статусыг хүлээн зөвшөөрдөг. Дайны үед төвийг сахих статусыг олон улсын эрх зүйгээр, тухайлбал,

Хуурай замын дайны үед төвийг сахисан улс, этгээдийн эрх, үүргийн тухай 1907 оны Гаагын V конвенц, Тэнгисийн дайны үед төвийг сахисан улсын эрх, үүргийн тухай 1907 оны Гаагын XIII конвенцоор зохицуулдаг. 1910 онд хүчин төгөлдөр болсон эдгээр конвенцид ОХУ, БНХАУ, АНУ, Герман, Япон, Франц зэрэг 37 улс оролцдог.

Харин байнга төвийг сахих статусыг олон улсын эрх зүйгээр зохицуулаагүй, өөрөөр хэлбэл байнга төвийг сахих статуст юу хамаарах, хэрхэн тогтоох, бусад улсаар хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай эсэхийг зохицуулсан олон улсын эрх зүйн баримт бичиг байхгүй юм.

Төвийг сахигч орны газар нутгийн халдашгүй дархан байдал олон улсын эрх зүйгээр давхар баталгааждаг. Үүнд агаарын болон усан хил нь ч ордог. Тийм орны газар нутагт бусад этгээдээс дайны үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Мөн дайтагч талын цэрэг зэвсгийг өөрийн нутгаар дамжуулахгүй байх эрх эдэлдэг. Энэ нь аливаа цэргийн эвсэлд гишүүнээр элсэх болон цөмийн зэвсгийн асуудалд ч хамаарна.

Аливаа улс “байнга төвийг сахих” статусаа аль нэг орон, олон улсын байгууллагаар заавал дэмжүүлэх албагүй. Гэхдээ тийм статус зарлагч орныг олон улсын харилцаанд “төвийг сахисан улс” гэж үзэж, бүртгэл статистикт оруулдаг. Харин хөршөөсөө эхлээд уг асуудлаар ойлголцож, цаашид бусад орон, олон улсын байгууллагаас дэмжлэг авахыг эрмэлзэх нь зүй ёсны алхамд тооцогдоно.

Монгол Улс төвийг сахих статус баримтлах тухай ярьж хэлэлцэхдээ бид юуны түрүүнд доорхи хүчин зүйлүүдийг бодолцох нь зүйтэй. Тухайлбал:

Нэг: Монгол Улс шинэ, ардчилсан Үндсэн хуулиа баталснаас хойш төвийг сахих бодлогыг агуулгын хувьд идэвхтэй хэрэгжүүлж иржээ.

Хоёр: Манай улсын туулж ирсэн түүх, газар зүйн байршил, сонгож авсан замын онцлог, эрх ашигт төвийг сахих статусын зарчим, мөн чанар нийцэж байгаа юм. Уг бодлого нь тухайн оронд бусад улстай эрх тэгш, тэнцвэртэй харилцах боломж олгодог. Мөн бусад улс орон, олон улсын байгууллага ч тийм бодлогод хүндэтгэлтэй ханддаг.

Гурав: Олон улсын байдал, дэг журам цагийн эрхээр өөрчлөгдөж, шинэчлэгдэх нь бий. Харин төвийг сахих үйл ажиллагаа нь хамгийн тогтвортой ордог. Учир нь уг статусыг хэрэгжүүлэгч улс оронд л тухайн бодлогоо засварлах, шинэчлэх, зогсоох онцгой бүрэн эрх хадгалагддаг.

Монголын эрх ашигт нэгдмэл, залгамжтай, тодорхой гадаад бодлого бол ус агаар лугаа адил. Төвийг сахих статус нь бидний хувьд нэг талаар байгаа хүч боломждоо улам тулгуурлах, нөгөө талаар бусадтай идэвхтэй, уян хатан харилцахад тустай, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэрэгсэл юм. Үүнийг олны амьдрал сургамжаар бүтээгдсэн нийтлэг үнэлэмж ч гэж үзэж болно.

Мөн дээрхи статус маань Монголоор төвлөх олон бодлого, үйл ажиллагааг идэвхжүүлэхэд ч нэмэр болох нь гарцаагүй.

Монгол Улсын газар нутгаа цөмийн зэвсэгээс ангид бүс болгон зарласныг дэлхийн улс орнууд болон хоёр хөрш их гүрэн эхнээс нь зарчмын хувьд дэмжсэн. Чингэснээр тэд Монгол Улсаас хөрш хоёр орны болон цөмийн зэвсэгтэй бусад гүрний цөмийн стратегийн холбогдолтой элдэв тооцоо, төлөвлөгөөнд татагдан орохгүй байж төвийг сахих бодлого баримтлах болсныг хүлээн зөвшөөрсөн хэрэг байв.³⁶ 1998 оны 12 дугаар сард НҮБ –ийн Ерөнхий Ассамблей “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал болон цөмийн зэвсгээс ангид статус”-ын тухай тогтоолыг санал хураахгүйгээр баталсан. Энэхүү тогтоолоор Монгол Улс газар нутгаа цөмийн зэвсгээс ангид бүс болгон зарласныг Ерөнхий Ассамблейн гишүүн улс орнууд болон Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн таван оронд мэдэгдэж хамтран ажиллаж дэмжихийг уриалсан байдаг.

Үндэсний Хэмжээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн дотроос 2000 оны 2 дугаар сард Монгол Улсын Их хурал “Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийг хэлэлцэж баталсан нь түүхэн чухал үйл явдал болсон билээ.

2010 онд шинэчлэн баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Гадаад бодлогын үзэл баримтлалд шинэ нөхцөлд аюулгүй байдлаа хангах зарчмуудыг суурилуулан хуульчилсан юм. Эдгээр нь дотооддоо үндэсний эв нэгдэл, эх оронч үзлийг дээдлэн, ардчилал, сайн засаглалыг бэхжүүлэх, гадаад бодлогын хүрээнд энхийг эрхэмлэх, олон улсын аюулгүй, тогтвортой байдалд өөрийн хувь нэмрээ оруулах улс төр-дипломатын арга юм.

Хамгийн явцуу, зааглалтай тодорхойлогддог оршин тогтнохын аюулгүй байдал ч өөрөө шинэ үзэл баримтлалын дагуу цогц байдлаар томъёологджээ. Тус баримт бичигт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр-дипломатын үйл ажиллагаа бөгөөд энэ хүрээнд “олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримталж, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжинэ”, “Ази, Номхон далайн бүс нутаг, Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцоно” хэмээн заасан

³⁶ Түвшинтөгс А. Хүйтэн дайны дараах Монголын аюулгүй байдлын гадаад орчин /Судалгааны бүтээлийн түүвэр/ Үндэсний Тагнуулын академи. УБ.,2012, 234-р тал.

байдаг.

Үзэл баримтлалд “даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байгаа” талаар тодорхой, нэн оновчтой тусгажээ. Үнэхээр ч дэлхийн олон улс орон ийм нөхцөлд аюулгүй байдлаа хангах шинэ арга хэлбэрүүдийг эрэлхийлж, олон улсын хамтын ажиллагаа, яриа хэлэлцээний арга, мөн “зөөлөн хүч”-ний стратегийг хэрэгжүүлэх болжээ.

Бүс нутаг болон дэлхий дахинд энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, тэнцвэртэй харилцах, бүс нутаг дахь цэргийн итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ, санал, санаачилгад идэвхтэй оролцох нь Монгол Улсын гадаад нэр хүндийг өсгөх “зөөлөн хүч”-ний бодлогын хэрэгжилт байгаад зогсохгүй мөн үзэл баримтлалд зааснаар үндэсний аюулгүй байдлаа хангах, тусгаар тогтнолоо хамгаалах үндсэн арга хэрэгсэл болж байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын төвийг сахих болсон нь дараах нөхцөл, хүчин зүйлүүдтэй салшгүй холбоотой. Үүнд: Монгол Улсын өөрийн геополитикийн нөхцөл байдалтай салшгүй холбоотой бөгөөд тусгаар тогтнолын түүхэн мөчлөг бүрт хөрш улсуудын гадаад улс төрийн бодлогын хайчинд өртөж байсныг харж болохоор байна.

Монгол Улс хөрш хоёр их гүрэнтэй адил тэнцвэртэй, бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал гэдгийг өөрийнхөө гадаад бодлогын үндсэн чиг баримжаа болгосон. Ингээд эдгээр улстай харилцах зарчмын цоо шинэ хандлагад тулгуурлан 1993 онд ОХУ-тай, 1994 онд БНХАУ-тай “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-г байгуулсан болно.

Үүний зэрэгцээ манай улс АНУ болон Зүүн Хойд Азийн бүс нутгийн нөлөө бүхий бусад оронтой идэвхтэй хамтран ажиллах чиг шугам буюу “Гуравдагч хөрш”-ийн хэмээн нэрлэдэг бодлогыг баримталж эхэлсэн бөгөөд үүнийгээ аль хэр ухаалаг, оновчтой, алсын хараатай хэрэгжүүлж чадахаас манай орны аюулгүй байдлын ирээдүй хамаарна.

Зүүн Хойд Азид аюулгүй байдал, хамтын ажиллагааны олон талт харилцаа төлөвшөөгүй явсаар өдийг хүрсэн. Монгол Улсын хувьд жижиг орны ашиг сонирхлыг хадгалах, урагшлуулах, хамгаалах, илэрхийлэх талбар хэмээн энэ бүс нутгаа үзэж, газар зүйн онцгой өвөрмөц байршилтай гэж товойлгож байваас бусдын анхаарлыг татах, бүс нутгийн талбар дээр хэн бэ гэдгийг мэдрүүлэхээс өөр гарц байхгүй юм.

Аюулгүй байдал талаасаа Зүүн Хойд Азийн бүс нутагт хоёр үндсэн хүчин зүйл, сорилт эрсдэл тулгарч болзошгүй гэж судлаачид үздэг. Энэ нь: нэгдүгээрт, Хөгжил дэвшил, хөгжлийн хурдын аяг даах эдийн засаг, үндэсний чадамж, оюуны мэдлэгээ шавхаж байж Зүүн Азийн эдийн засгийн эрчимтэй хөдөлгөөн, өрсөлдөөнд тэсч үлдэх. Тэгж эс чадвал Монгол шиг эмзэг эдийн засагтай улс тоглолтын гадна үлдэх аюул бий. Хоёрдугаарт, Солонгосын хойгийн тодорхойгүй нөхцөл байдлаас үүсэж болзошгүй цэргийн аюул занал, эсвэл тэнд мөргөлдөөн дэгдсэнээс учрах аюулгүй байдлын эрсдлүүд зэрэг юм.

Төвийг сахих статус бол Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогыг хэрэгжүүлэх нэг хэрэгсэл, иймд:

- НҮБ-ын мандаттай энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоно.
- Зүүн Хойд Азийн аюулгүй байдлыг бэхжүүлэх үйл хэрэгт идэвхтэй оролцож, зуучлах боломжийг эрэлхийлнэ.

Монгол Улсын байнгын төвийг сахих статус бол гадаад бодлогын өөрчлөлт биш. Ялангуяа, хоёр хөрштэйгөө харилцах Монгол Улсын гадаад бодлогын суурь зарчимд өөрчлөлт орохгүй. Уг статусыг “*де юре*” зарлаж буй явдал бол хоёр хөрштэйгөө эн тэнцүү харилцахаа нотолж буй хэрэг боловч одоогоор албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа юм.

Олон улсын харилцаанд “Монгол Улс төвийг сахих явцдаа, сөргөлцөж буй улс орнуудын аль нэгний талд орохгүй, тэдэнтэй ижил тэнцүү харилцах, хандах зарчмыг баримтлана” гэсэн хэдий ч үүгээр манай улсын, олон улсын хууль, НҮБ-ын дүрэм, бусад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчиж бусад улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд зэвсгийн хүчээр халдсан үйлдлийг эсэргүүцэх, шүүмжлэх эрхийг хязгаарлахгүй.

Төвийг сахиснаар Монгол Улс терроризмын эсрэг тэмцэл болон хүний эрхийг хамгаалах үйлсэд болон НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаа төдийгүй НҮБ-ын аюулгүйн зөвлөлөөс зөвшөөрсөн олон улсын бусад ажиллагаанд НҮБ-ын дүрмийн VI, VII бүлгийн аль алины үйлчлэлд хамаарах хүрээнд оролцох нөхцөл боломжтой. Тодруулбал, НҮБ-ын мандаттайгаар энхийг сахиулах /*peace keeping*/ үйл ажиллагаанд нэгдэн орох боломжтой. Харин энхийг тогтоох /*peace making*/ ажиллагаанд оролцохгүй байвал оновчтой. Түүнчлэн НҮБ-ын эдийн засгийн хориг арга хэмжээнд нэгдэх эрхтэй байна.

Байнгын төвийг сахих статус бол мөнхийн байр суурь биш бөгөөд манай улсын эрх ашигт сөргөөр нөлөөлөх тохиолдолд түүнийг цуцлах эрх, Монгол Улсад хэдийд ч хадгалагдсан хэвээр байх бөгөөд цаашид төвийг сахих статусаа хүлээн зөвшөөрүүлэхийн тулд Хаагийн 1907 оны V; XIII конвенцид даруй нэгдэх шаардлагатай болно.

Монгол Улс төвийг сахих статусаа албан ёсоор зарлаж буй явдал

бол илүү хариуцлагатай улс болж буйн илэрхийлэл. Гэхдээ Камбож улс “төвийг сахих” статусаа 1957 Үндсэн хуулиараа зарласан байдаг боловч бодит байдал дээр энэ статусыг нь олон улсад хүлээн зөвшөөрөөгүй 34 жил үргэлжилсэн үйл явц өрнөснийг санахад илүүдэхгүй юм. Мөн 2014 оноос “Европын холбооны гишүүн орнууд аюулгүй байдлын томоохон сорилуудтай тулгарахад төвийг сахигч, эвсэлд үл нэгдэх орнуудын зүгээс тусалж, дэмжиж бараг чадсангүй; Донецк, Луганск мужийн салан тусгаарлах оролдлоготой холбоотой Украины дотоодод зэвсэгт мөргөлдөөн болж, 2014 оны 3 дугаар сард Крым Украины бүрэлдэхүүнээс гарч ОХУ–д хүчээр нэгдэв; Сири улсын задрал хурцадсан бөгөөд цаашид асуудал шийдэгдэх найдлага харагдахгүй байна. Ирак, Сирийг дамнасан Исламын бүлэглэл Иракийг ч задралд хүргэв. Исламын бүлэглэлийн явуулсан удаа дараагийн террорист ажиллагааны улмаас олон мянган хүн дүрвэж, шашны цөөнхийг алан хядах ажиллагаа явуулсаар байна. Ливи улс задарсан, Хамасын зөрчил сэдэрч дайны хэмжээнд хүрсэн. Түүнчлэн Хойд Африкаас дүрвэгчдийн урсгал Европ руу цувж байна”³⁷. Энэ мэтчилэн бодит болон болзошгүй гадаад аюулгүй байдалд нь заналхийлж буй нөхцөл байдлыг Европын төвийг сахисан улс орнууд хэрхэн даван туулах талаарх арга зам, гаргалаа хайсаар байгаа бөгөөд иргэний болон цэргийн түвшинд нягт хамтарч сөрөн зогсохоо илэрхийлсээр байгаа юм. Дээрхээс харахад байнгын төвийг сахих статусыг баримтлахад гадаад талаас учирч болзошгүй аюул, занал, бусад хүчин зүйлийг маш сайн харгалзан үзсэний үндсэн дээр уян хатан зохицуулалт хийх шаардлага харагдаж байна.

Түүнчлэн Монгол Улсын төвийг сахих статусыг 2016 оны 7 дугаар сард болсон АСЕМ-ын чуулганаар албан ёсоор хүлээн зөвшөөргүй үлдээсэн явдалд дүгнэлт хийж, энэ чиглэлээр гаргасан бодлогын баримт бичгүүдээ судалж, эргэн тодотгох шаардлагатай мэт.

Эцэст нь ХХ зууны Монголын тусгаар тогтнолын баталгаажилт, уналт, бууралтын түүхэн хувьслын үр дүн нь тухайн үед дэлхийд шинэ тоглогч болон гарч ирж байсан Дундад Иргэн Улс, Зөвлөлт Холбоот Улс, АНУ, Япон зэрэг улсуудын геополитикийн ашиг сонирхлын давхцал, зөрчил, тэдгээрийн хоорондын ил, далд нууц хийсэн гэрээ хэлцлүүд, улс төрийн үйл явцуудаас үүдэлтэй бөгөөд түүхэн тодорхой хугацааны дараа төвийг сахих статус руу аажмаар хөтлөн оруулсныг нотлон харуулж байна.

НОМ ЗҮЙ

[1] Цацрал П. Олон улсын харилцааны онолын үндэс, Геополитик судлал. УБ.,2016

³⁷ Гунтер Хаузер. Европын орнуудын төвийг сахих, эвсэлд үл нэгдэх бодлого. Стратегийн судалгааны хүрээлэн. УБ.,2016, 12-р тал.

- [2] Түвшинтөгс А. Хүйтэн дайны дараах Монголын аюулгүй байдлын гадаад орчин. Үндэсний Тагнуулын академи. УБ.,2012
- [3] Дагважамц Г. XXI зууны эхэн үеийн Монгол Улсын геополитикийн орчин. УБ.,2014
- [4] Котвич Вл. Монголын түүхийн хураангуй тэмдэглэл ба түүний эдүүгээгийн улс төрийн байдал. СП.,1914. УБ.,2011
- [5] Наками Тацүо “Үндэстэн улсаа байгуулахыг зорьсон нь: Монголын тусгаар тогтнолын 1911 оны тунхаглал” Монголын тусгаар тогтнол ба монголчууд. ЭШБХ. Ред С.Чулуун УБ.,2012
- [6] Урангуа Ж. Монголын тусгаар тогтнол: Орос-Хятадын 1913 оны Бээжингийн тунхаг. УБ.,2012
- [7] Гунтер Хаузер. Европын орнуудын төвийг сахих, эвсэлд үл нэгдэх бодлого. Стратегийн судалгааны хүрээлэн. УБ.,2016
- [8] Нартов Н.А. Геополитик. УБ.,2003, 30-р тал
- [9] Бямбасүрэн Д. Монголчуудад мэдлэгээ баялаг болгохуйн ухаан хэрэгтэй байна. Өдрийн сонин. УБ.,2016,12
- [10] How the Russia-China Strategic Partnership Marks a New Global Power Shift, by Pepe Escobar <http://www.alternet.org/world/how-russia-china-strategic-partnership-marks-new-global-power-shift>